

ГАЛУУТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Огноо: 2020.02.07.

**БАГА СУРГУУЛИЙН ДОТУУР БАЙРНЫ ХҮҮХДИЙН ХООЛНЫ  
МАТЕРИАЛ НИЙЛҮҮЛЭХ ГҮЙЦЭТГЭГЧИЙГ СОНГОН  
ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Гэрээний нэр, дугаар: Бага сургуулийн дотуур байрны хүүхдийн хоолны материал  
**БХАГСЗДТГ/202001004/**

**2020 он**

## **Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА**

**Баянхонгор аймгийн Галуут сумын Засаг даргын Тамгын газар нь**  
сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос : **Бага сургуулийн ДОТУУР  
БАЙРНЫ хүүхдийн хоолны материал /БХАГСЗДТГ/202001004/** // нийлүүлэх  
тухай цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа тендер  
тул [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон тендерийн  
баримт бичгийг авна уу. Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг  
илгээхийн өмнө 50,000 / тавин мянган төгрөгийг/ цахим систем ашиглан төлсөн  
байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30** хоногийн дотор хүчинтэй байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад  
материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг [**2020 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 14 цаг 00  
минут**]-аас өмнө өөрийн аж ахуй нэгжийн цахим гарын үсэг, хувийн нууцлалын  
кодоор [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) сайтад нэвтэрч цахимаар ирүүлэх ба нээлтэд оролцох  
хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг [**2020 оны 02 дугаар  
сарын 17-ны өдрийн [14 цаг 30 минут]**]-д ЗДТГ-ын Иргэний танхим 101 тоот  
өрөөнд нээнэ.

Дотоодын давуу эрх тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх  
хаягаар авч болно.

**Баянхонгор аймгийн Галуут сумын Засаг даргын Тамгын газар  
(1 давхар 103 тоот 70446241, Санхүүгийн албаны дарга Ж. Баярсайхан  
утас 88549958 1)**

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- |  |   |
|--|---|
| <p><b>1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа</b></p> | <p>1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.</p>  |
| <p><b>2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт</b></p>               | <p>2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.</p> <p>2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.</p> <p>2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.</p> |
| <p><b>3. Тендерийн иж бүрдэл</b></p>                           | <p>3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:</p> <p>(а) Үнийн санал;</p> <p>(б) Үнийн боло нийлүүлэлтийн хуваарь;</p> <p>(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;</p> <p>(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;</p> <p>(д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]</p>  |
| <p><b>4. Тогтмол үнэ</b></p>                                   | <p>4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.</p>   |
| <p><b>5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд</b></p> | <p>5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.</p> <p>5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.</p>  |
| <p><b>6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа</b></p>           | <p>6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.</p>   |

- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **TШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

**Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

<b>ТОӨЗ-НЫХОЛБОГОХЗААЛТ</b>	<b>Шалгуур үзүүлэлт</b>
<b>ТОӨЗ 1.1</b>	<ol style="list-style-type: none"> <li>1. Энэхүү тендерийн бичиг баримтад тусгагдсан жишиг маягтын дагуу үнийн саналыг гаргаж баталгаажуулан ирүүлэх</li> <li>2. Нийлүүлэлтийн баталгаажуулсан график ирүүлэх</li> <li>3. Улсын бүртгэлийн гэрчилгээг нотариатаар баталгаажуулсан хуулбар /Үйл ажиллагааны чиглэл дээр хүнсний бараа бүтээгдэхүүн худалдаа, үйлчилгээ эрхэлдэг байх/</li> <li>4. Урт хугацааны болон хугацаа хэтэрсэн зээлтэй эсэх талаар Монгол банкны тодорхойлолт эсхүл харилцагч бүх банкнаас ирүүлэх</li> <li>5. Харилцагч Татварын байгууллагаас өр төлбөргүй тухай лавлагаа тодорхойлолтыг өөрийн тендертээ хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд цахим системээр дамжуулан Татварын ерөнхий газрын татвар төлөгчдийн мэдээллийн сан e-balance-аас тендерт оролцогчдын татвар төлөлт, санхүүгийн тайлангаас борлуулалтын орлого, шаардлагатай мэдээллийг шалгана. /Тендер нээсэн өдрийн байдлаар өргүй байх/</li> <li>6. Шүүхийн байгууллагаас сүүлийн 1 жилтэй холбогдох тодорхойлолт ирүүлэх.</li> <li>7. Шүүхээр шийдвэрлэгдсэн өртэй эсэх талаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт ирүүлэх. /Хугацаа тендер нээсэн өдрийн байдлаар хүчинтэй байх/</li> <li>8. Тухайн тендерт оролцогч, түүний нийлүүлэх бараа нь захиалагчийн шаардсан техникийн тодорхойлолт болон стандартад нийцэж буйг нотлох баримт, , агуулах, барааг бүтэн жилийн хугацаанд тасралтгүй, гэрээний дагуу нийлүүлэх боломжтойг нотлох баримт фото зураг зэрэг холбогдох мэдээллийн хамт тусгайлан бэлтгэж ирүүлэх.</li> <li>9. 2019 онд хийсэн ижил төстэй ажил гүйцэтгэсэн бол гэрээний хэрэгжилтийн талаар захиалагч байгууллагаас тодорхойлолт авч ирүүлэх.</li> <li>10. 2019 оны санхүүгийн тайлангийн борлуулалтын орлогын дүн санал болгож буй үнийн дүнгийн 10%-с багагүй</li> <li>11. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ санал болгож буй үнийн дүнгийн 5%-с багагүй</li> <li>12. Тендерт оролцогч нь уг тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ, хугацаанд багтаан техникийн тодорхойлолтын дагуу чанарын өндөр түвшинд тухайн барааг нийлүүлэн хүлээлгэн өгөх баталгааг албан бичгээр гаргаж ирүүлнэ.</li> <li>13. Тендерт оролцогч нь уг тендерт шалгарсан тохиолдолд өөрийн зардлаар, өөрийн унаагаар компанийн ажилтанаас бусад хүнээр гар дамжуулалгүй барааг хүлээн авах газарт хүлээлгэн өгч байх баталгааг албан бичгээр гаргаж ирүүлэх.</li> <li>14. Татвар, хураамж, төлбөрөө төлсөн эсэхийг тендер нээсэн өдрөөр тооцино. Татвар, нийгмийн даатгал, банк, бусад байгууллагад хугацаа хэтэрсэн өр төлбөртэй, мөн шүүх, ШШГГ-ын байгууллагуудаас ирүүлсэн тодорхойлолтоор ямар нэгэн шийтгэл авч байсан нь нотлогдсон тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.</li> <li>15. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн</li> </ol>

	<p>14.1-д заасан нөхцөл байхгүйг бичгээр ирүүлэх. /Тендерт оролцогч нь үнэлгээний хорооны гишүүдэд нөлөөлөх, нөлөөлөхийг оролдсон нь баримтаар нотлогдвол тендерээс татгалзана./</p> <p>16. ТШӨХ-д заасан материалуудын аль нэгийг ирүүлээгүй тохиолдолд уг тендерээс татгалзах үндэслэл болно.</p> <p>Тендерт оролцогч аж ахуй нэгж нь тендерийн баримт бичгийн дагуу материалаа эмх цэгцтэй, харагдахуйц тод бэлтгэж ирүүлнэ. /Ирүүлсэн материалын харагдах байдал хангалтгүй тохиолдолд тухайн материалыг хангалтгүйд тооцож үнэлгээнд харгалзахгүй/</p>
<b>ТОӨЗ 2.1</b>	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p><b>2020 оны 02 дугаар сарын 17-ны өдөр Цаг: 14 цаг 00 минут</b></p> <p>Цахим тендерийн урилгад заасан тендер хүлээн авах эцсийн хугацаа нь цахим системийн серверийн цагаар тооцогдох бөгөөд хугацаа хоцорсон тендерийг хүлээж авахгүй.</p>
<b>ТОӨЗ 2.1</b>	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <b>Галуут сумын Засаг даргын Тамгын газар</b></p> <p>Давхар болон өрөөний дугаар: <b>[1 давхар, 104 тоот Иргэний танхим]</b></p> <p>Огноо: <b>[2020 оны 02 дугаар сарын 17 -ны өдөр Цаг: 14 цаг 30 минут]</b></p>

<b>ТОӨЗ 2.3</b>	Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ.
<b>ТОӨЗ 6.2</b>	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: багцгүй

## Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

- 1. Барааны тодорхойлолт**
- 2. Стандарт:** Монгол улсад мөрдөгдөж байгаа холбогдох стандартад нийцсэн байна
- 3. Баглаа, боодол:** Зориулалтын сав баглаа
- 4. Бараа хүргэх газар:** Галуут сумын Бага сургууль

### 5. Бараа нийлүүлэлтийн хуваарь:

#### **БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ**

№	Нэр төрөл	Тодорхойлолт, шаардлага	Хэмжих нэгж	Тоо ширхэг
1	1-р гурил	1-р гурил /Улаанбаатар гурилтай дүйцэхүйц/ тэжээллэг чанар өндөртэй	кг	600
2	2-р гурил	2-р гурил /Улаанбаатар гурилтай дүйцэхүйц/ тэжээллэг чанар өндөртэй	кг	200
3	Цагаан будаа	Слава, Сакура будаатай дүйцэхүйц	кг	100
4	Элсэн чихэр	Ширхэг нарийн Орос сахартай тэнцэхүйц	кг	30
5	Ургамлын тос	Олейна тостой дүйцэхүйц	ш	30
6	Масло	Орос масло дүйцэхүйц	ш	100
7	Хониньи маx	Шинэ, хэт тарган биш, махны гарц ихтэй, өнгө үзэмж сайтай, муудаагүй,	кг	300
8	Үхрийн маx	Шинэ, хэт тарган биш, махны гарц ихтэй, өнгө үзэмж сайтай, муудаагүй, гарал үүслийн гэрчилгээтэй	кг	1000
9	Хөөлгөгч	Орос хугацаа хэтрээгүй	ш	50
10	Давс	Орон нутгийн байгалийн улаан давс	кг	20
11	Үзэм	Орос улсын бор үзэм, хатаагүй түүнтэй дүйцэхүйц	кг	30
12	Аарц	Нутгийн үнээний амт чанартай, гадны хольцгүй цэвэр аарц	кг	75
13	Тараг	Нутгийн үнээний исээгүй шинэ элгэн тараг	л	80
14	Сүү	Орон нутгийн хадгалалтын горим алдаагүй	л	150
15	Чацаргана	Үйлдвэрийн өтгөрүүлсэн гарал үүслийн гэрчилгээтэй хугацаа дуусаагүй	кг	30
16	Төмс	Шинэ сортын холбогдох стандартад нийцсэн	кг	80
17	Байцаа	Шинэ сортын холбогдох стандартад нийцсэн	кг	150
18	Манжин	Шинэ сортын холбогдох стандартад нийцсэн	кг	40
19	Лууван	Шинэ сортын холбогдох стандартад нийцсэн	кг	150
20	Сонгино	Таримал сонгино, ялзарч муудаагүй	кг	25
21	Гоймон	Сонгинотой луувантай хугацаа хэтрээгүй	кг	30
22	Өрмөн тос	Амттай хөгцгүй, ямар нэгэн хольцгүй	кг	25
23	Варень	Хугацаа хэтрээгүй	ш	15
24	Далайн байцаа	Солонгос байцаа түүнтэй дүйцэхүйц	ш	30
25	Бор будаа	Орос, хугацаа хэтрээгүй, гарал үүслийн гэрчилгээтэй	кг	20
26	Хэлбэртэй гоймон	Оросын славатай дүйцэхүйц хугацаа хэтрээгүй	кг	15
27	Цай	Ногоон цай холбогдох стандартад нийцсэн орос улсад үйлдвэрлэсэнтэй дүйцэх	ш	9
28	Шар будаа	Оросын слава түүнтэй дүйцэхүйц	кг	30
29	Бүхэл үрийн гурил	Сайн чанарын хугацаа хэтрээгүй	кг	40
30	Хивэгний гурил	Холбогдох стандартад нийцсэн	кг	15

Бараа нийлүүлэлтийн хуваарь:

### БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

№	Нэр төрөл	Тодорхойлолт, шаардлага	Бараа нийлүүлэх хугацаа
1	1-р гурил	1-р гурил /Улаанбаатар гурилтай дүйцэхүйц/ тэжээллэг чанар өндөртэй	Сараар
2	2-р гурил	2-р гурил /Улаанбаатар гурилтай дүйцэхүйц/ тэжээллэг чанар өндөртэй	Сараар
3	Цагаан будаа	Слава, Сакура будаатай дүйцэхүйц	Сараар
4	Элсэн чихэр	Ширхэг нарийн Орос сахартай тэнцэхүйц	Сараар
5	Ургамлын тос	Олейна тостой дүйцэхүйц гарал үүслийн гэрчилгээтэй	Сараар
6	Масло	Орос масло дүйцэхүйц гарал үүслийн гэрчилгээ	Сараар
7	Хонины мах	Шинэ, хэт тарган биш, махны гарц ихтэй, өнгө үзэмж сайтай, муудаагүй, гарал үүслийн гэрчилгээтэй	14 хогот
8	Үхрийн мах	Шинэ, хэт тарган биш, махны гарц ихтэй, өнгө үзэмж сайтай, муудаагүй, гарал үүслийн гэрчилгээтэй	14 хогот г
9	Хөөлгөгч	Орос түүнтэй дүйцэх хугацаа хэтрээгүй	Сараар
10	Давс	Орон нутгийн байгалийн улаан давс	Сараар
11	Үзэм	Орос улсын бор үзэм, хатаагүй бэлцгэр	Сараар
12	Аарц	Нутгийн үнээний амт чанартай, гадны хольцгүй цэвэр аарц	Сараар
13	Тараг	Нутгийн үнээний исээгүй шинээлгэн тараг	Сараар
14	Сүү	Галуут сумын малчдаас худалдан авсан түүхий сүү	Сараар
15	Чацаргана	Үйлдвэрийн өтгөрүүлсэн гарал үүслийн гэрчилгээтэй хугацаа дуусаагүй	Сараар
16	Төмс	Шинэ сортын холбогдох стандартад нийцсэн	7 хоног тутамд
17	Байцаа	Шинэ сортын холбогдох стандартад нийцсэн	7 хоног тутамд
18	Манжин	Шинэ сортын холбогдох стандартад нийцсэн	7 хоног тутамд
19	Лууван	Шинэ сортын холбогдох стандартад нийцсэн	7 хоног тутамд
20	Сонгино	Таримал сонгино, ялзарч муудаагүй	7 хоног тутамд
21	Гоймон	Сонгинотой луувантай хугацаа хэтрээгүй	Сараар
22	Өрмөн тос	Амттай хөгцгүй, ямар нэгэн хольцгүй	Сараар
23	Варень	Хугацаа хэтрээгүй	Сараар
24	Далайн байцаа	Солонгос түүнтэй төстэй	Сараар
25	Бор будаа	Орослава түүнтэй дүйцэхүйц, хугацаа хэтрээгүй, гарал үүслийн гэрчилгээтэй	Сараар
26	Хэлбэртэй гоймон	Орос чанартай дүйцэхүйц хугацаа хэтрээгүй	Сараар
27	Цай	Ногоон цай	Сараар
28	Шар будаа	Оросын слава түүнтэй дүйцэхүйц	Сараар
29	Бүхэл үрийн гурил	Сайн чанарын хугацаа хэтрээгүй	Сараар
30	Хивэгний гурил	Холбогдох стандартад нийцсэн	Сараар

## Дөрөв. ЖИШИГ МАЯГТ

### 1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

- Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [моо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
- Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
- Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

- Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгднө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## 2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/фак с	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

## Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

<b>1. Шалгах болон турших</b>	1.1.	Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.
<b>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт</b>	2.1.	Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.
<b>3. Оюуны өмчийн эрх</b>	3.1.	Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.
<b>4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх</b>	4.1.	Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томьёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
<b>5. Баталгаат засварын хугацаа</b>	5.1.	Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа <b>[тоо]</b> жил байна.
<b>6. Гэрээнд өөрчлөлт оруулах</b>	6.1.	Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.
<b>7. Төлбөр</b>	7.1.	Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш <b>[ГТН-д заасан тоо]</b> хоногийн дотор шуурхай хийнэ.
<b>8. Бараа нийлүүлэх хуваарь</b>	8.1.	Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
<b>9. Алданги оногдуулах</b>	9.1.	Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.
<b>10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах</b>	10.1.	Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.
<b>11. Маргааныг шийдвэрлэх</b>	11.1.	Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- |   |   |
|---|---|
| <b>1. Шалгах болон турших (ГЕН – 1)</b>   | 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]   |
| <b>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)</b>   | 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд: <ol style="list-style-type: none"><li>1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;</li><li>2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;</li><li>3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;</li><li>4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;</li><li>5) барааны гарал үүслийн гэрчилгээ.</li></ol> |
| <p>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.</p> |   |
| <b>3. Баталгаат засвар (ГЕН-5)</b>  | 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.<br>[Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]   |
| <b>4. Төлбөр (ГЕН – 7)</b>  | 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:<br><br>Гэрээний үнийн дүнгийн <b>[too]</b> <sup>1</sup> хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.  |
| <b>5. Алданги оногдуулах (ГЕН - 9)<sup>2</sup></b>  | 9.1. Алданги оногдуулах хувь: <b>[too]</b><br>Алдангийн нийт дүн: <b>[too]</b>  |

<sup>1</sup> Ихэнх тохиолдолд 100 хувь байна. Шаардлагатай бол төлбөрийн хуваарийг өөрчилнэ.

<sup>2</sup> Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

## Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ<sup>3</sup>

БАТЛАВ.

### ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)  
(Гарын үсэг)  
(Албан тушаал)

### НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)  
(Гарын үсэг)  
(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [нийлүүлэгчийн нэр] (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны\_сарын\_-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бутээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “бараа” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг\_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь\_\_\_\_\_нэр төрлийн барааг\_\_\_\_\_оны \_\_\_\_ дугаар сарын\_\_\_\_ -наас\_\_\_\_\_оны\_дугаар сарын\_-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай баримт бичиг<sup>4</sup>;  
Үнийн санал;  
Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.

<sup>3</sup> Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

<sup>4</sup> Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг]

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг]

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

